



АРЬС СУДЛААЧДЫН МОНГОЛЫН
НИЙГЭМЛЭГИЙН ТӨРГҮҮН
Б. ДАШЛХҮМБЭ

Арьс, харшил судлалын
мэргэжлийн салбар зөвлөлийн
2026 оны 03 дугаар сарын 13-ны
өдрийн 03 дугаар хурлын шийдвэр.
Хавсралт 2

АХЛАХ зэрэг горилогч эмнэлгийн мэргэжилтэн нь дараах тусгай шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Тасралтгүй суралцагч байх. Дор дурьдсанаас аль нэгийг нотлох баримтаар ирүүлэх:
 - 1.1. Багц цагийн 12 кредитээс доошгүй сургалтад суусан байх
 - 1.2. Төгсөлтийн дараах мэргэжил дээшлүүлэх сургалтад сурсан байх
 - 1.3. Гадаад сургалтын байгууллага, эмнэлэгт эмнэлзүйн чиглэлээр богино хугацааны сургалтад хамрагдаж мэргэжил дээшлүүлсэн байх
2. Эмнэлзүйн туршлага хуримтлуулсан асуудлыг бие даан шийдвэрлэх чадвартай байх. Дор дурьдсан нотлох баримтыг ирүүлэх:
 - 2.1. Арьс судлалаар төрөлжсөн тусламж, үйлчилгээ үзүүлдэг, тусгай зөвшөөрөл бүхий эмнэлэгт арьсны эмчээр 4-с доошгүй жил ажилласан байх
3. Судлаач байх. Дор дурьдсанаас аль нэгийг нотлох баримтаар ирүүлэх:
 - 3.1. Нэгдүгээр зохиогч эсхүл хариуцлагатай зохиогчоор илтгэл танилцуулсан эсхүл өгүүлэл хэвлүүлсэн байх
 - 3.2. Дотоодын сэтгүүлд хамтарсан зохиогчоор 3-аас доошгүй бүтээл хэвлүүлсэн байх
 - 3.3. Олон улсын хуралд аман эсхүл ханын илтгэл хэлэлцүүлж эсхүл бүтээлийн хураангуй илгээж оролцсон байх

ТЭРГҮҮЛЭХ зэрэг горилогч эмнэлгийн мэргэжилтэн нь дараах тусгай шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Тасралтгүй суралцагч байх. Дор дурьдсанаас аль нэгийг нотлох баримтаар ирүүлэх. Ахлах зэрэг авсанаас хойш:
 - 1.1. Мэргэжлийн чиглэлээр 10 кредитээс доошгүй сургалтад суусан эсхүл заасан байх
 - 1.2. Гадаад сургалтын байгууллага, эмнэлэгт эмнэлзүйн чиглэлээр 1 сараас доошгүй хугацаагаар мэргэжил дээшлүүлсэн байх
2. Эмнэлзүйн ховор тохиолдлыг дангаар юуу багаар шийдвэрлэх туршлагатай бусдад мэргэжлийн зөвлөгөө өгөх, зааж сургах, байгууллагын асуудлыг цогцоор харж зохион байгуулах, баг удирдах чадвартай байх. Дор дурьдсан нотлох баримтыг ирүүлэх:
 - 2.1. Арьс судлалаар төрөлжсөн тусламж, үйлчилгээ үзүүлдэг, тусгай зөвшөөрөл бүхий эмнэлэгт арьсны эмчээр 8-с доошгүй жил ажилласан байх
3. Судлаач байх. Дор дурьдсанаас аль нэгийг нотлох баримтаар ирүүлэх. Ахлах зэрэг авсанаас хойш:
 - 3.1. Эмнэлзүйн ховор тохиолдол, эмнэлзүйн судалгаа... гм хийж нэгдүгээр зохиогч эсхүл хариуцлагатай зохиогчоор илтгэл танилцуулсан эсхүл өгүүлэл хэвлүүлсэн байх
 - 3.2. Дотоодын сэтгүүлд хамтарсан зохиогчоор 3-аас доошгүй бүтээл хэвлүүлсэн байх
 - 3.3. Олон улсын хуралд аман эсхүл ханын илтгэл хэлэлцүүлж эсхүл бүтээлийн хураангуй илгээж оролцсон байх

ЗӨВЛӨХ зэрэг горилогч эмнэлгийн мэргэжилтэн нь дараах тусгай шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Манлайлагч байх. Дор дурьдсанаас аль нэгийг нотлох баримтаар ирүүлэх:
 - 1.1. Арьс судлалын чиглэлээр мэргэжил арга зүйн бодлогын баримт, бичиг боловсруулах батлуулахад 5-аас дээш удаа оролцсон байх
 - 1.2. Мэргэжлийн чиглэлээр 1-с доошгүй ном, сурах бичиг хэвлүүлсэн эсхүл 2-с доошгүй номын бүлэг бичиж хэвлүүлсэн байх
2. Ментор байх: Эмнэлзүйн ховор тохиолдлыг бие даан эсхүл олон мэргэжлийн багаар шийдвэрлэх чадвартай, салбарын асуудлыг цогцоор нь харж хөгжүүлэх чиглэлээр идэвх санаачлагатай ажилласан байх. Дор дурьдсан нотлох баримтыг ирүүлэх:
 - 2.1. Залуу эмч мэргэжилтнүүдийг дагалдуулан дадлагажуулах, мэргэжил аргазүйгээр хангаж ажилласан байх
 - 2.2. Мэргэжлийн салбар зөвлөлд ажилласан байх
 - 2.3. Эмнэлзүйн сургагч багш байх

3. Судлаач байх. Дор дурьдсанаас аль нэгийг нотлох баримтаар ирүүлэх:

- 1.1. 1-р зохиогч эсхүл хариуцлагатай зохиогчоор 3-с доошгүй илтгэл танилцуулсан эсхүл өгүүлэл хэвлүүлсэн байх
- 1.2. Дотоодын сэтгүүлд хамтарсан зохиогчоор 5-аас доошгүй бүтээл хэвлүүлсэн байх
- 1.3. Олон улсын хуралд аман эсхүл ханын илтгэл хэлэлцүүлж эсхүл бүтээлийн хураангуй 3-с доошгүйг илгээж оролцсон байх

